

Үндэсний хөгжлийн газрын даргын  
2020.. оны 08. сарын 08. өдрийн 14:00т  
тушаалын 6.. хавсралт

УХА0588  
6098177  
1116127253

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (цаашид УХОХ гэх) төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, уг хөтөлбөрт тусгах үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшинг үнэлж, харьцуулахад энэхүү аргачлалын зорилго оршино.
- 1.2. Боловсруулах үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшинг үнэлэхэд чиглэгдсэн энэхүү аргачлалын дагуу хийсэн технологийн түвшний үнэлгээний үр дүнг дараах зорилгуудаар ашиглана. Үүнд:
  - Төслийн технологийн шинэ, шинэлэг, инноваци шингэсэн байдал, хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллийг үнэлэх;
  - Хөрөнгө оруулалтын төслийн үйлдвэрлэлийн төлөвлөлтийг хийх;
  - Ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлүүдийг харьцуулах;
  - Нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өөр өөр технологиудыг харьцуулах;Салбарын тогтвортой хөгжлийн эхиц дэвшлийг үнэлэх;

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - "тогтвортой үйлдвэрлэл" гэж хүний хэрэгцээнд нийцсэн, амьдралын чанарыг сайжруулж, байгалийн нөөц, хортой материал, хог хаягдал, бохирдуулагч бодисын ашиглалт зэргийг багасгах үйлдвэрлэлийг эрхлэхийг;
  - "хаягдал материалын ашиглалт" гэж үйлдвэрлэлээс гарсан хаягдал материалыг дахин боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл дараагийн үйлдвэрт шилжүүлэхийг;
  - "экологийн цэвэр бүтээгдэхүүн" гэдэгт цэвэр байгалийн болон хөдөө аж ахуйн гаралтай, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлчлэлгүй, боловсруулалтын шатанд нь хэрэглэгддэг химийн болон бусад төрлийн бодис, нэмэлтүүд, тэдгээрийн хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй, байгаль орчинд халгүй технологиор үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг;
  - "эко бүтээгдэхүүнээс олох орлого" гэж эко шошготой, эко стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээс болох орлогыг;
  - "био сав баглаа боодол" гэж био органик материалаар хийгдсэн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль түргэн шингэдэг сав баглаа боодлын материалын шинж чанарыг;
  - "төсөл санаачлагч" гэж УХОХ-т тусгах төслийн хувьд төслийг санал болгож буй Төсвийн ерөнхийлөн захирагч, бусад төслийн хувьд төслийн санааг гарган, хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй иргэн, хуулийн этгээдийг;
  - "эксперт" гэж үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшинг хараат бусаар үнэлж, үнэн бодитой дүгнэлт гаргахад шаардлагатай мэдлэг, ур чадвартай, өөрийн мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, энэ чиглэлээрээ манлайлах туршлагатай, насан туршдаа суралцаж, бусдын сайн тал, давуу талыг олж харж чаддаг мэргэжилтнийг;

- “технологийн түвшний үнэлгээ” гэж уг технологиор бий болгосон бүтээгдэхүүн, явуулж буй үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, үр ашгийг нөхцөлүүлэгч нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хүчин зүйлийн цогц нөлөөллийг тодорхойлсон тоон илэрхийлэл буюу нэгдсэн үнэлэлт, дүгнэлтийг;

## **ГУРАВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 3.1. Үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшнийг үнэлгээг хийхдээ үнэн бодит тооцоо судалгаа, мэдээ, мэдээлэл, нотлох баримтад үндэслэнэ.
- 3.2. Төсөл санаачлагч нь үнэлгээ хийхдээ шаардлагатай тооцоо судалгаа, мэдээ, мэдээлэл, нотлох баримтын үнэн зөв, бодитой байдлыг бүрэн хариуцна.
- 3.3. Төслийн технологийн түвшний үнэлгээг хийж буй эксперт нь шударга, хариуцлагатай, ил тод, ёс зүйтэй байж, гагцхүү нотлох баримтад үндэслэн мэргэжлийн түвшинд ажиллана.
- 3.4. Технологийн түвшнийг үнэлгээ хийхдээ тогтвортой үйлдвэрлэлийн хандлага баримтлах ба шалгуур үзүүлэлтүүдийг тухайн төсөл хөнгөн, хүнсний салбарын аль дэд салбарт хамаарахаас шалтгаалан сонгож, холбогдох тохируулгудыг хийнэ.
- 3.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, үнэлгээ хийх экспертийг сонгохдоо тухайн эксперт төсөл хэрэгжих салбар, дэд салбар, түүний үйлдвэрлэлийн технологийн талаар өндөр мэдлэгтэй, судалгаа, шинжилгээнд сууриссан дүгнэлт гаргах чадвартай, мэргэжлээрээ дундаж мэргэжилтнээс илүү өргөн хүрээтэй, тусгай мэдлэг эзэмшсэн, нарийн мэргэшсэн, технологийн судалгааны туршлагатай, технологийн үнэлгээний арга зүйн талаар ойлголттой байх зарчмыг баримтална. Өөрөөр хэлбэл тухайн экспертийн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргахад хангалттай түвшний мэдлэг, чадвар, туршлагатай, нарийн мэргэшсэн мэргэжилтэнг сонгоно.
- 3.6. Технологийн түвшний үнэлгээ хийх гэж буй төслийн техник эдийн засгийн үндэслэл, бусад холбогдох судалгааны баримт бичигт дараах мэдээллийг заавал тусгасан байх ба мэдээллийн цар хүрээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:
  - Технологийн дэвшилтэй байдал  
Төхник, тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэрэглээ, зардал, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ
  - Материал ашиглалтын үзүүлэлт, материал дахин ашиглах боломж, эко материал ашиглалт
  - Усны болон бохирдлын хэмжээ, зардал, байгаль хор хөнөөлгүй шингэх боломж
  - Химийн болон аюултай материалын хэрэглээ, түүний хаях, аюулгүйжүүлэх үйл ажиллагаа
  - Нийгмийн хандив, үйл ажиллагаа, орон нутгийн оршин суугчдын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж, ажлын цаг, цалингийн хэмжээ
  - Технологийн судалгаа шинжилгээний зардал
  - Эко бүтээгдэхүүн, сав баглаа боодлын зардал
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал, эрүүл мэндийн арга хэмжээ
  - Бусад

## **ДӨРӨВ. ТӨСЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

- 4.1. Үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшинг тогтвортой үйлдвэрлэлийн хандлагын үндсэн тулгуур болох дараах 3 багц үзүүлэлтүүдээр үнэлнэ.

а. Нийгмийн хүчин зүйлс - Өргөн утгаараа хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны түүхэн ёсоор хөгжиж буй хэлбэр, явцуу утгаараа хүн төрөлхтний түүхийн тодорхой шат, материаллаг амьдралын түүхэн тодорхой нөхцөлд нэгдсэн хүмүүсийн үйл ажиллагааны цогц үндсэн бүрэлдэхүүнийг хэлнэ.

б. Байгаль орчны хүчин зүйлс - Хүний гараар бүтээгдээгүй, аяндаа бий болсон зүйлсийн бүрэлдэхүүнүүдийг хэлнэ.

в. Эдийн засгийн хүчин зүйлс - Үйлдвэрлэх хүчний хөгжлийн тухайн шатанд тохирч буй үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэлийн харьцааны цогцосын бүрэлдэхүүнүүдийг хэлнэ.

4.2. Багц бүр үндсэн ба дэд шалгуур үзүүлэлтүүдээс тогтох ба үнэлгээг хийхдээ нийгмийн 4, байгаль орчны 7, эдийн засгийн 2 үзүүлэлт, нийт 13 үндсэн шалгуур үзүүлэлт, 89 дэд шалгуур үзүүлэлтээс тухайн төсөл хэрэгжих салбарын онцлогоос хамааруулан сонгон авсан шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд хийнэ.

4.3. Багц тус бүр нь дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Үүнд:

#### 4.3.1. Нийгмийн хүчин зүйлс

- Ажилгүйдэл: Ажилгүй бөгөөд ажил бэлэн, ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг хэлнэ.
- Боловсролын систем: Хувь хүний эзэмшсэн тогтолцоот мэдлэг, чадвар; мэргэжилийн горим, тогтолцоо
- Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд:

Аюулгүй ажиллагаа гэдэг нь ямар нэгэн хор хөнөөлгүй урьдаас зохион байгуулалттай хийж гүйцэтгэх ажлыг;

Эрүүл мэнд гэдэг нь дан ганц өвчин эмгэггүй байгаад зогсохгүй бие бялдар сэтгэл санаа болон нийгмийн сайн сайхан байдлыг хэлнэ.

- Орон нутгийн хөдөлмөр эрхлэх боломж: Тухайн засаг захиргаан дахь хэрэгцээг хангах зорилгоор байгалийн юмсыг өөрчлөх, тохиромжтой болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг хүний зохистой үйл ажиллагаа ба ажлыг бие дааж дагнаж гүйцэтгэх бололцоог бий болгохыг хэлнэ.

#### 4.3.2. Байгаль орчны хүчин зүйлс

- Эрчим хүчний хэрэглээний шалгуур үзүүлэлтүүд: Цахилгааны үйлдвэрлэл, энергийн стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрт бий болиух өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ
- Материалын хэрэглээний шалгуур үзүүлэлтүүд:
- Усны хэрэглээний үзүүлэлтүүд. Булаг шанд, гол горхи, нуур цоором, далай тэнгисийг үүсгэж байгаа устэрөгч, хүчилтөрөгч хоёрын химиин цэвэр нэгдэл болох тунгалаг, өнгөгүй, байгалийн нэгэн шингэн зүйлээр хэрэгцээгээр хангах стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.
- Бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтүүд: Хэрэгцээгээ хангах зорилгоор зах зээлд нийлүүлэгдэж буй бүх зүйлс бөгөөд түүний стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ
- Хатуу хог хаягдлын үзүүлэлтүүд: Хэвийн дулаанд хатуу чанараа хадгалж чаддаг, ган, төмөр, чулуу, мод, шил зэрэг хэрэглэгдэхгүй болсон эд юмсын хэмжиж чадах, урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.

- Шингэн хог хаягдлын үзүүлэлтүүд: Өтгөн биш, урсамтгай шинж чанартай хэрэглэгдэхгүй болсон эд юмсын хэмжиж чадах, урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.
  - Агаарын ялгарлын үзүүлэлтүүд: Хүн, амьтан, ургамлын амьдралд зайлшгүй чухал азот, хүчилтөрөгч бүхий хийн нэгдэлийн ялгарч буй урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.
- 4.3.3. Эдийн засгийн хүчин зүйлс
- Санхүүгийн үзүүлэлт: Улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг мөнгөн хөрөнгө, төрийн зүгээс түүнийг зохицуулан ашиглах үйл ажиллагааны урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.
  - Ажилллах хүчний үзүүлэлт: Ажил хийх чадвартай хүмүүсийн урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг хэлнэ.
- 4.4. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн тодорхойлолт, тооцох аргачлал, хэмжих нэгж, үзүүлэлтийн уттын шинж чанар зэргийг Хавсралт 1-д багц тус бүрээр үзүүлэв.
- 4.5. Дэд шалгуур үзүүлэлтүүдийг нь уттын шинж чанараар биет тоон үзүүлэлт (санхүүгийн үзүүлэлт г.м), чанарын үзүүлэлт (экспертийн үнэлгээ г.м.), хувийн жингийн үзүүлэлт (хэрэглээ, зарцуулалт г.м) гэж хуваан үзнэ.

#### **ТАВ. ТӨСЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ, ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ТӨСЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ**

- 5.1. Төслийн технологийн түвшнийг үнэлгээг дараах үе шатуудаар гүйцэтгэнэ. Үүнд:
  - 5.1.1. **Ye шат 1.** Тухайн төсөл хэрэгжих дэд салбарыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас заасан ангиллын дагуу тодорхойлно.
  - 5.1.2. **Ye шат 2.** Шалгуур үзүүлэлтүүдийг сонгох чиг үүрэгтэй, экспертэд тавигдах шаардлагыг хангасан 5-аас доoshгүй экспертийг сонгоно.
  - 5.1.3. **Ye шат 3.** Экспертүүд бие даасан байдлаар Хавсралт 1-д үзүүлсэн дэд шалгуур үзүүлэлтүүдээс тухайн төслийг хэрэгжүүлэх дэд салбарын төслийн технологийн түвшинг хамгийн сайн үнэлж чадах 40 хүртэл тооны үзүүлэлтийг сонгоно.
  - 5.1.4. **Ye шат 4.** Экспертүүдийн бие даан сонгосон үзүүлэлтүүдийг нэгтгэн санал нийцлийн түвшинг Хавсралт 2-т үзүүлсэн маягтын дагуу тодорхойлж, 75%-с дээш байгаа үзүүлэлтүүдийг сонгон Хавсралт 3-т үзүүлсэн маягтын дагуу үнэлгээний хуудсыг бэлтгэнэ.
  - 5.1.5. **Ye шат 5.** Өмнөх шатанд бэлтгэсэн Үнэлгээний хуудсаар а. УХОХ-т тусгах төсөл бол Төсвийн ерөнхийлөн захирагч болон Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёулаа, б. бусад зорилгоор ашиглах төслүүдийн хувьд төслийг үнэлэх үүрэг хүлээсэн этгээд төслийн технологийн түвшний үнэлгээг хийнэ.
  - 5.1.6. УХОХ-т тусгах төслийн хувьд Төсвийн ерөнхийлөн захирагч болон Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёрын үнэлгээний дунджаар Хавсралт 4-т үзүүлсэн маягтын дагуу нэгдсэн дүгнэлтийг гаргана.
  - 5.1.7. **Ye шат 6.** Дэд шалгуур үзүүлэлт нэг бүрийн үнэлгээг дараах хүснэгтийн дагуу 0-1 онооны хязгаарт хөрвүүлнэ. Ингэж хөрвүүлэхдээ тухайн дэд шалгуур үзүүлэлт сөрөг нөлөөг илэрхийлж байвал (1-а) оноо өгөх буюу сөрөг нөлөө багатайг нь өндөр оноогоор үнэлэх зарчим баримтална.

Хувийн жингийн үзүүлэлтийн утга	Хөрвүүлсэн оноо	Тоон үзүүлэлтийн утга	Хөрвүүлсэн оноо	Чанарын үзүүлэлтийн утга	Хөрвүүлсэн оноо
>90	1	<0	1	Маш өндөр нөлөөтэй	1
80-90	0.9	0-1	0.9	Өндөр нөлөөтэй	0.9
70-80	0.8	1-2	0.8	Нөлөөтэй	0.8
60-70	0.7	2-3	0.7	Дундаж нөлөөтэй	0.7
50-60	0.6	3-4	0.6		0.6
40-50	0.5	4-5	0.5		0.5
30-40	0.4	5-6	0.4		0.4
20-30	0.3	6-7	0.3		0.3
10-20	0.2	7-8	0.2		0.2
0-10	0.1	8-9	0.1		0.1
<0	0	>9	0	Огт нөлөөгүй	0

**Үе шат 7.** Дэд шалгуур үзүүлэлтуудийн хөрвүүлсэн оноонуудын арифметик нийлбэрийг бодож, нийт авбал зохих онооны хэдэн хувийг авсаныг тооцоолно. Энд нийгмийн, байгаль орчны, эдийн засгийн хүчин зүйлс нь тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд ижил ач холбогдолтой гэж үзнэ.

**Үе шат 8.** Дээрх нийлбэр нь нийт авбал зохих онооны хэдэн хувийг авсанаар төслүүдийг Хавсралт 3-т үзүүлсэн маягтын дагуу эрэмбэлнэ. Технологийн түвшний үнэлгээний үр дүнгээр хамгийн өндөр хувиар эрэмбэлэгдсэн төсөл нь хамгийн дэвшилтэт, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн төсөл буюу "байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө" хамгийн багатай төсөл гэж үзэн сонгоно.

- 5.2. Хэрэв төсөл нь УХОХ-т тусгах төсөл бол энэхүү үнэлгээний үр дүнг "УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэнд хяналт тавих аргачлал"-ын "Төслийн иж бүрэн үнэлгээ"-ний 2.4.3-ийн "Үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшинг үнэлэх аргачлалд суурилсан үнэлгээ" гэсэн үзүүлэлттэй уялдуулан дараах хүснэгтийн дагуу З хүртэл оноо руу хөрвүүлж, төслийн үнэлэх, эрэмбэлэхэд ашиглана.

Технологийн түвшний үнэлгээ, хувиар	Оноо
Дэвшилтэт, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө багатай төсөл буюу технологийн түвшин 75%-с дээш үнэлгээтэй	0
Технологийн түвшин 50%-75%-ийн үнэлгээтэй	2
Технологийн түвшин 50%-с доош үнэлгээтэй	1
Технологийн түвшний үнэлгээ хийгдээгүй, эсхүл үнэлэхэд шаардлагатай мэдээлэл байхгүй	0

## ХАВСРАЛТУУД

Хавсралт I. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Томъёо	Хэмжих нэгж	Утгын шинж чанар	Тайлбар
<b>1. Нийгэм үзүүлэлт</b>					
1	Үйлдвэрлэлийн ажилчдын бүтээмж	Ажилчдын тоо/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгж	1/UP	хувь	Нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэдэн ажилчид оролцож байгаагаар илэрхийлэгдэнэ. Харьцаа өндөр байх тусам нийгэмд зөргөтөөтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
2	Ажилчдын эргэлт	Ажлаас халагдсан эсвэл цомхотголд орсон ажилчдын тоо/нийт ажилчдын тоо	1/1=1	хувь	Нийт ажилчдын тоонд ажлаас халагдсан эсвэл цомхотгол орсон ажилчдын тооны залэх хувийн жин. Харьцаа өндөр байх тусам нийгэмд серег нөлөөтэй гэж үзэн үнэлгээ бага (1-α) байна.
3	Цалингийн харьцаа	Ажилчдын өндөр цалин 10 хувь/ ажилчдын бага цалинтай 10 хувь	төг/төг=1	хувь	Ажил хөдөлмөр, алба гүйцэтгэсний төлөө тогтмол олгох мөнгөн хөлслний ижил төрлийн болон өөр өөр хэмжигдэхүүн, юм, үйл явдлыг харуулсан жишиг
4	Сэтгэл ханамжтай ажилчдын хэсэг	Сэтгэл ханамжтай ажилчдын тоо/нийт ажилчдын тоо	1/1=1	хувь	Тухайн хөдөлмөр хийж буй хүмүүсийн хэрхэн зөргөтөөтэй гэж талаас нь үнэлж байгааг илтгэдэг.
5	Идэвхжүүлэлтийн хувь	Идэвхтэй ажилчдын тоо/нийт ажиллагсад	1/1=1	хувь	Олон нийт, хамт олны дотор үүрэг хүлээсэн хийгээд хүлээгээгүй боловч идэвх зүтгэл бүхий хүмүүсийн залэх хувь
6	Ажилчдын өвчлөлийн цаг	Осол гэмтэл, өвчний улмаас ажлын өдөр	өдөр	тоо	Ажлын өдрүүдэд бие махбодын хэвийн үйл ажиллагаа алдагдаж хямрах эрүүл биш байдал, үзэгдэх цаг хугацаа
7	Хүмүүнлэгийн үйл ажиллагаа	Нийгмийн хандив/нийт орлого	төг/төг=1	хувь	Хүнлэг, энэргийн сайн сайхны төлөө зохио нь байгуулалттай хийж гүйцэтгэх ажил
8	Олон нийтийн төслийн тоо	Компаний хэрэгжүүлсэн олон нийтийн төслийн тоо	1	chanar	Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн үйл ажиллагаанд оруулж буй хөрөнгө оруулалт, хийж буй төслийн тоо, түүний нөлөөллийн чанараар илэрхийлэгдэнэ. Экспертийн үнэлгээгээр ач холбогдол өндөр байх тусам үнэлгээ өндөр байна.
9	Дотоодын хэрэглээний үзүүлэлт	Дотоодод борлуулсан бүтээгдэхүүний нэгж/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгж	кг/кг=1	хувь	МУ-ын нутаг дэвсгэр дахь хүн амын өдөр тутмын амьжираганы бүрэлдэхүүн хэсэг
10	Хүн амын өсөлтийн хувь	Орон нутагт хүн амын өсөлтийн хувь	1	хувь	Тодорхой хугацааны туршид хүн амын тооны зөргөтөөтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
<b>2. Байгаль орчны үзүүлэлт, 2.1 Орцын үзүүлэлт 2.1.1 Эрчим хүчиний хэрэглээ</b>					
1	Зарцуулсан эрчим хүч	Нийт эрчим хүч зарцуулалт	kВт.ц	тоо	Нийт эрчим хүчиний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээсэн нийт метаны хийн хэмжээг хэлнэ.
2	Нэгж бүтээгдэхүүнд ноогдох эрчим хүч	Зарцуулсан эрчим хүч/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгж	kВт.ц /UP	тоо	Нэгж kВт.ц эрчим хүчээр хэдэн бүтээгдэхүүнд үйлдвэрлэж байгаагаар илэрхийлэгдэнэ. Харьцаа бага байх тусам байгаль орчин зөргөтөөтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
3	Эрчим хүчиний эх үүсвэр	Эрчим хүчиний нэг эх үүсвэрийн хэрэглээ/нийт эрчим хүчиний хэрэглээ	kВт.ц/ kВт.ц =1	тоо	Эрчим хүчиний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг хэлнэ. Эрчим хүчиний нэг эх үүсвэрийн хэрэглээг нийт эрчим хүчиний хэрэглээтэй харьцуулсан харьцаа
4	Сэргээгдэх эрчим хүчиний хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчиний хэрэглээ/нийт эрчим хүчиний хэрэглээ	kВт.ц/ kВт.ц =1	тоо	Эх үүсвэрийг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх байгууламжийг ашиглан үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг хэлнэ. Сэргээглэх эрчим хүчиний хэрэглээг

					нийт хэрэглээтэй харьцуулсан харьцаа
5	Дахин хэрэглэсэн эрчим хүч	Дахин хэрэглэсэн эрчим хүч	кВт.ц	тоо	Нэг ба түүнээс дээш ашиглагдсан эрчим хүчиний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг гаргахад зарцуулагдаж буй зардлыг хэлнэ.
6	Нийт зарцуулсан эрчим хүч	Хэрэглэсэн нийт эрчим хүч/Борлуулсан бүтээгдэхүүний өртөг зсвэл нэмэгдсэн өртөг	кВт.ц /төг	тоо	Нийт хэрэглэсэн эрчим хүчийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй харьцуулана.
7	Эрчим хүчиний зардал	Харьцангуй	төг	тоо	Ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг гаргахад зарцуулагдаж буй зардлыг хэлнэ.
8	Эрчим хүчиний зардлын хэсэг	Нийт эрчим хүчиний зардал/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зардал	төг/төг	хувь	Нийт үйлдвэрлэлийн зардалд эрчим хүчиний зардлын эзлэх хувийг харуулна. Харьцаа бага байх тусам байгаль орчин зэрэг гэж үзэн үнэлгээ ёндер байна.
9	Эрчим хүчиний дундаж зардал	Эрчим хүчиний зардал/эрчим хүчиний хэрэглээ	төг/ кВт.ц	тоо	Эрчим хүчиний зардал болон хэрэглээг харьцуулж эрчим хүчиний дундаж зардлыг харуулна.

## 2. Байгаль орчны үзүүлэлт, 2.1 Орцын үзүүлэлт 2.1.2 Материалын хэрэглээний үзүүлэлт

1	Нийт материалын хэрэглээ	Харьцангуй утга	кг	чанар	Үйлдвэрлэлд зарцуулсан материалын хэмжээг харуулна. Бусад ижил төрлийн үйлдвэрлэлтэй харьцуулах зсвэл стандарт хэмжээнээс хамаарч экспертийн үнэлгээ өгнө. Бага байх тусам ёндер үнэлгээтэй байна.
2	Онцлог материалын хэрэглээ	Онцлог материалын хэрэглээний хэмжээ/үйлдвэрлэлийн гарц	кг/UP	тоо	Бусдаас ялгарахаа өвөрмөц шинж чанар бүхий хэрэглэгдэхүүн, биет, бодит юм, түүхий эд, бүтээгдэхүүн
3	Сэргээгдэх материалын хэрэглээ	Сэргээгдэх материалын орц/нийт материалын орц	кг/кг=1	хувь	Нийт материалын орцод хичнээн хэмжээний ору материалын орох
4	Түүхий эдийн үр ашиг	Үйлдвэрлэлийн гарц/түүхий эдийн орц	кг/кг=1	тоо	Нэгж түүхий эдээр хэдий хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг харуулна. Түүхий эдийн хэмжих нэгж нь хүндийн хэмжээ зсвэл зардлын хэмжээгээр илэрхийлгэдэнэ. Харьцуулагдах нэгж ижил байх ёстой. Харьцаа ёндер байх тусам үнэлгээ ёндер байна.
5	Хаягдал материалын ашиглалт	Хаягдал материалын орц/нийт материалын орц	кг/кг	хувь	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд хаягдал материалын ашиглалтын хэмжээний хувийг харуулна. Харьцаа ёндер байх тусам үнэлгээ ёндер байна.
6	Аюултай материал	Тоо хэмжээ	1	хувь	Хор хөнөөл агуулсан эх хэрэглэгдэхүүн, биет, бодит юм, түүхий эд, бүтээгдэхүүнийг хэлнэ.
7	Аюултай материалын орц	Харьцангуй хэмжээ	кг	чанар	Хор хөнөөл агуулсан эх хэрэглэгдэхүүн, биет, бодит юм, түүхий эд, бүтээгдэхүүнийг бий болгоход ашиглагдсан хэрэглэгдэх зүйлс
8	Нийт материалын зардал	Зардал	төг	тоо	Материалд шаардлагдсан нийт зардлыг хэлнэ.
9	Материалын үзүүлэлт	Нийт материалын орц/Борлуулсан бүтээгдэхүүний өртөг зсвэл нэмүү өртөг	кг/төг	тоо	Нийт үйлдвэрлэлийн зардалд материалын зардлын эзлэх хувийг харуулна. Харьцаа бага байх тусам байгаль орчин зэрэг гэж үзэн үнэлгээ ёндер байна.

## 2.Байгаль орчны үзүүлэлтүүд, 2.1 Орцын үзүүлэлтүүд, 2.1.3 Ус ашиглах үзүүлэлтүүд

1	Нийт усны хэрэглээ	Харьцангуй утга	м <sup>3</sup>	тоо	Үйлдвэрлэлийн процес дахь нийт ашиглагдсан усны хэрэглээг хэлнэ.
2	Усны хэрэглээ	Усны хэрэглээний хэмжээ/үйлдвэрлэлийн гарц	м <sup>3</sup> /UP	тоо	Усны хэрэглээ нь үйлдвэрлэлд процес дахь усны хэрэглээг харуулна. Усны хэмжээ болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэгжийн харьцаагаараа илэрхийлдэг. Усны хэрэглээ бага байх тусам үнэлгээ ёндер гэж үзээ.

3	Саарал усны ашиглалт	Саарал усны хэмжээ /нийт усны хэмжээ	$m^3/m^3$	хувь	Үйлдвэрлэлийн процессоос гарсан бохирдол багатай усыг дахин процесст ашиглахыг хэлнэ. Саарал ус ашиглалтын хэмжээ их байх тусам байгальд зөрөг гэж үзэн үнэлгээ өндөр байна.
4	Нийт усны зардал	Харьцангуй эзэлхүүн	төг	тоо	Нийт усанд хэрэглээнд зарцуулалтадсан зардал
5	Усны хэрэглээний зардлын хэмжээ	Дахин ашигласан усны зардал/үйлдвэрлэлийн нийт зардал	төг/төг	хувь	Үйлдвэрлэлийн нийт зардалд усны зардлын эзлэх хувивар илэрхийлэгдэнэ. Харьцаа бага байх тусам усны хэрэглээний бага, байгаль орчинд зөрөг гэж үзэн үнэлгээ өндөр байна.
6	Нэгж бүтээгдэхүүний усны зардал	Усны зардал/нийт үйлдвэрлэлийн гарц	төг/төг=1	тоо	Нэгж бүтээгдэхүүнд хичнээн хэмжээний ус ашиглахдаас шалтгаалан гарч буй зардал
7	Дахин ашигласан усны зардал	Дахин ашигласан усны зардал/нийт усны зардал	$t\cdot g/m^3$	хувь	Нэгээс дээш ашиглагдсан ус болон нийт усны зардалтай харьцуулсан харьцаа.
2. Байгаль орчны үзүүлэлтүүд, 2.2 Гарцын үзүүлэлтүүд, 2.2.1 Бүтээгдэхүүний үзүүлэлтүүд					
1	Байгаль орчны шошготой бүтээгдэхүүний үзүүлэлт	Байгаль орчны тэмдэгтэй бүтээгдэхүүн/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	$kg/kg=1$	хувь	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд байгаль орчны тэмдэгтэй бүтээгдэхүүн хичнээн хувийг илтгэж байгааг харуулна.
2	Дахин ашигласан материалын ашиглалтын үзүүлэлт	Дахин боловсруулсан материалылаар хийсэн бүтээгдэхүүн/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	$kg/kg=1$	хувь	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд дахин боловсруулалтадсан материал хичнээн кг ноогдож байгаа үзүүлэлт
3	Дахин ашиглах эсвэл дахин боловсруулах, бүтээгдэхүүний үзүүлэлт	Дахин боловсруулсан материалын ашиглалт/нийт материалын хэмжээ	$kg/kg=1$	хувь	Дахин ашиглах болон боловсруулах материалын ашиглалт нь нийт материалын хэмжээ хичнээн кг ноогдож буй үзүүлэлт
4	Бүтээгдэхүүний эдэлгээ	Эдэлгээний хугацаа	өдөр	тоо	Үйлдвэрлэлийн үйлдвэрэн гаргасан материал нь хичнээн цаг хугацаанд ашиглагдах
5	Эко бүтээгдэхүүнээс олох орлого	Харьцангуй утга	төг	тоо	Эко бүтээгдэхүүнээс олох орлого гэдэг нь эко шошготой, эко стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээс болох орлогыг хэлнэ.
6	Эко бүтээгдэхүүнээс олох орлого нийт орлогод эзлэх хувь	Эко бүтээгдэхүүнээс олох орлого/нийт орлого	төг/төг=1	хувь	Нийт орлогод эко бүтээгдэхүүнээс олох орлого хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ.
7	Нийт сав баглаа боодол	Харьцангуй жин	$kg, sh g.m.$	тоо	Юм агуулах, хийхэд зориулсан эдлэл, хэрэглэлийн нийт хэмжээ
8	Бүтээгдэхүүний сав баглаа боодлын хэмжээний үзүүлэлт	Сав баглаа боодол/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	$kg/kg=1$	хувь	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд хичнээн хэмжээний сав боодол ноогдох үзүүлэлт
9	Био сав баглаа боодлын үзүүлэлт	Байгальд эзлтэй сав баглаа боодол/нийт сав баглаа боодлын хэмжээ	$kg/kg=1$	тоо	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт сав баглаа боодолд эко сав баглаа боодол хэдэн хувийг эзэлж байгааг харуулна. Эко сав баглаа боодол хэмжээ өндөр байх тусам байгаль орчинд эзлтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
10	Сав баглаа боодлын зардал	Сав баглаа боодлын зардал/үйлдвэрлэлийн нийт зардал	төг/төг	хувь	Үйлдвэрлэлийн нийт зардалд сав баглаа боодлын зардлын эзлэх хувийг харуулна. Сав баглаа боодлын зардал бага байх тусам байгаль орчинд эзлтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
11	Нэгж бүтээгдэхүүнд ногдох сав баглаа боодлын зардал	Сав баглаа боодлын зардал/үйлдвэрлэлийн гарц	төг/UP	тоо	Нэгж бүтээгдэхүүнийг агуулах, хийхэд зориулагдсан хэрэглэлд шаардагдах төгрөг
2. Байгаль орчны үзүүлэлтүүд, 2.2 Гарцын үзүүлэлтүүд, 2.2.2 Хатуу хог хаягдлын үзүүлэлтүүд					

1	Хатуу хог хаягдлын нийт хэмжээ	Харьцангуй утга	кг	тоо	Хэвийн дулаанд хатуу чанараа хадгалж чаддаг, ган, төмөр, чулуу, мод, шил зэрэг хэрэглэгдэхгүй болсон эд юмсийн нийт хэмжээ
2	Материалын хог хаягдлын хэмжээ	Хог хаягдлын хэмжээ/үйлдвэрлэлийн гарц	кг/UP	тоо	Үйлдвэрлэлийн гарцад хаягдал материалын орцын хэмжээг харуулна. Харьцаа өндөр байх тусам байгаль орчинд эзлтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
3	Сэргээгдэх хатуу хаягдал	Дахин ашиглах хатуу хог хаягдлын хэмжээ	кг	тоо	Дахин ашиглаглаж болохуйц хэвийн дулаанд хатуу чанараа хадгалж чаддаг, ган, төмөр, чулуу, мод, шил зэрэг
4	Дахин ашиглагдахгүй хог хаягдал	Дахин ашиглагдахгүй хог хаягдлын хэмжээ	кг	тоо	Нийт хог хаягдалд дахин ашиглаж буй хог хаягдлын хэмжээг харуулна. Харьцаа өндөр байх тусам байгаль орчинд эзлтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.
5	Дахин ашиглагдах хог хаягдлын хэмжээ	Дахин боловсруулагдах хатуу хог хаягдал/нийт хог хаягдал	кг/кг=1	хувь	Нийт хог хаягдлыг дахин боловсруулах хатуу хог хаягдалтай харьцуулсан харьцааны хэмжээ
6	Дахин ашиглагдахгүй хог хаягдлын хэмжээ	Дахин боловсруулагдахгүй хог хаягдал/нийт хог хаягдал	кг/кг=1	хувь	Дахин ашиглагдахгүй боломжгүй хог хаягдалыг нийт хог хаягдалтай харьцуулсан үзүүлэлт
7	Аюултай хог хаягдлын хэмжээ	Аюултай хог хаягдлын хэмжээ/нийт хог хаягдал	кг/кг=1	хувь	Хор хенеөл учруулж болзошгүй хог хаягдлыг нийт хог хаягдалтай харьцуулсан үзүүлэлт
8	Аюултай хог хаягдлын хэмжээ	Байгаль орчинд аюултай хог хаягдлын хэмжээ	кг	тоо	Байгаль орчинд хор хенеөл учруулах аюултай хог хаягдалыг хэмжээ
9	Нийт хог хаягдлын зардал	Харьцангуй утга	төг	тоо	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд хог хаягдлаас шалтгаалсан зардалын үзүүлэлт
10	Хог хаягдлын зардалын хэмжээ	Нийт хог хаягдлын зардал/үйлдвэрлэлийн зардал	төг/төг=1	хувь	Нийт үйлдвэрлэлийн зардалд хог хаягдлын зардалын эзлэх хувь хэмжээг харуулна. Харьцаа бага байх тусам үнэлгээ өндөр байна.

2. Байгаль орчны үзүүлэлтүүд, 2.2 Гарцын үзүүлэлтүүд, 2.2.3 Шингэн хог хаягдлын үзүүлэлтүүд

1	Бохир усны хэмжээ	Харьцангуй утга	м <sup>3</sup>	тоо	Физик, химийн шинж чанараараа ялгагдах бохирдуудыг агуулсан усны хэмжээ
2	Бохирдлын харьцаа	Бохир усны хэмжээ/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгж	м <sup>3</sup> /UP	тоо	Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжид бохир усны хэмжээ ноогдох үзүүлэлт
3	Бохирдуулаагүй шингэн хаягдлын хэмжээ	Харьцангуй утга	м <sup>3</sup>	тоо	Ямар нэгэн физик, химийн шинж чанараараа ялгагдах бохирдуудыг агуулаагүй өтгөн биш урсамттай хог хаягдлын хэмжээ
4	Бохирдсон шингэн хаягдлын хэмжээ	Харьцангуй утга	м <sup>3</sup>	тоо	Үнд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэн гарч, өөрийн анхдагч химийн найрлага, физик шинж чанараа өөрчлөн бохирдсон урсамттай хаягдлын хэмжээ
5	Тодорхой бохирдлын массын харьцаа (химийн)	Бохирдуулсан усны хэмжээ/үйлдвэрлэлийн гарц	м <sup>3</sup> /UP	тоо	Бохирдлыг массын харьцаа гэдэг нь бохир ус болон химийн бохирдлын хэмжээг харуулна. Үүнийг 1 тн усанд дахь химийн хаягдлын хэмжээ эсвэл бохир усны хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
6	Шингэн хаягдал дахь бохирдлын массын концентраци	Бохирдуулагчийн масс/шингэн хаягдлын хэмжээ	кг/м <sup>3</sup>	тоо	Бохирдуулагч масс болон шингэн хаягдлын хэмжээний харьцууласан үзүүлэлт
7	Шингэн хаягдлын нийт зардал	Харьцангуй утга	төг	тоо	Урсамттай шинж чанар бүхий хаягдалд зарцуулагдаж буй нийт зардалын хэмжээ
8	Шингэн хаягдлын зардал	Бохир усны зардал/үйлдвэрлэлийн нийт зардал	төг/төг	хувь	Нийт үйлдвэрлэлийн зардалд бохир усны зардалын хэмжээг харуулна. Харьцаа бага байх тусам байгаль орчинд эзлтэй гэж үзэн үнэлгээ өндөр байна.

2. Байгаль орчны үзүүлэлтүүд, 2.2 Гарцын үзүүлэлтүүд, 2.2.4 Агаарын бохирдол үзүүлэлтүүд

1	Хүлээмжийн хийн массын хэсэг	CO <sub>2</sub> эквивалентуудын нийт масс/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	кг/кг=1	тоо	Нийт үйлдвэрлэлийн хэмжээнд нүүрс төрөгийн нийт массыг харьцуулсан үзүүлэлт
---	------------------------------	---	---------	-----	---

2	Хүлэмжийн хийн ялгаруулалт	CO2 эквиваленттүүдийн нийт масс/Борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөг	кг/төг	тоо	Цацраг түявг өөртөө шингээж авсан цацруулдаг нэгэн төрлийн агаарын давхарга буюу хүлэмжийн хийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт харьцуулсан харьцаа
3	Хүчиллэг хийн масс	SO2 эквиваленттүүдийн нийт масс/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	кг/кг=1	тоо	Нийт үйлдвэрлэлийн хэмжээг хүчиллэг хийн массад харьцуулсан харьцаа буюу хэмжээ
4	Хүчиллэг хийн эрчим	SO2 эквиваленттүүдийн нийт масс/Борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөг	кг/төг	тоо	Нүүрс төрөгчийн эквиваленттүүдийн нийт массыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөгийн харьцуулсан харьцаа
5	Азон үүсгэх фотохимийн хэмжээ	Этилиний нийт масс/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	кг/кг=1	тоо	Этилиний нийт массын хэмжээг нийт үйлдвэрлэлийн хэмжээнд харьцуулсан харьцаа
6	Азон үүсгэх фотохимийн эрчим	Этилиний нийт масс/ Борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөг	кг/төг	тоо	Этилиний нийт массын хэмжээг борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөгийн дунд харьцуулсан харьцаа
7	Евтрофиксийн массын хэмжээ	Евтрофиксийн нийт масс/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	кг/кг=1	тоо	Евтрофиксийн нийт массын хэмжээг нийт үйлдвэрлэлийн хэмжээнд харьцуулсан харьцаа
8	Евтрофиксийн массын эрчим	Евтрофиксийн нийт масс/ Борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөг	кг/төг	тоо	Евтрофиксийн нийт массыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл нэмүү өртөгийн дунд харьцуулсан үзүүлэлт
9	Агаарын бохирдлын зардал	Харьцангуй утга	төг	тоо	Хүн ба бусад амьд биетээс шалтгаалсан хувилажийн болон амин бодисууд, элдэв тоосжилтын нелөөнд агаар мандалын байгалийн шинж чанар өөрчлөгдсөнөөс үүдсэнээс үүдсэн зардал
10	Агаарын бохирдлын зардалын харьцаа	Агаарын бохирдлын зардал/нийт үйлдвэрлэлийн хэмжээ	төг/төг=1	хувь	Агаарын бохирдлын зардалыг нийт үйлдвэрлэлийн хэмжээнд харьцуулсан харьцаа

3. Эдийн засгийн үзүүлэлтүүд, 3.1 Санхүүгийн үзүүлэлтүүд

1	ДНБ-ний үзүүлэлт	Нэмэгдсэн өртөг/ДНБ	төг/төг	тоо	Нэмэгдсэн өртгийг шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэрийн үзүүлэлттэй харьцуулсан үзүүлэлт
2	Тогтвортой хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын үнэ цэнэ	Компани судалгаа шинжилгээний зардал/үйлдвэрлэлийн зардал	төг/төг	хувь	Үйлдвэрлэлийн нийт зардал судалгаа шинжилгээний зардалын эзлэх хувийг харуулна. Харьцаа өндөр байх тусам үнэлгээ өндөр байна.
3	Байгаль орчныг хамгаалахад оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнэ	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр компанийн хөрөнгө оруулалт	төг	чанар	Байгаль орчин хамгаалахад оруулах хөрөнгөөр илэрхийлэгдэнэ. Экспертийн үнэлгээнд үндэслэнэ.
4	Байгаль орчны хариуцлагын зардал	Байгаль орчинд учруулсан хохирлын хариуцлагын зардал	төг	чанар	Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрөөр илэрхийлэгдэнэ. Экспертийн үнэлгээнд үндэслэнэ.
5	Гомдол гаргасан хэрэглэгчдийн тоо	Гомдлын тоо/борлуулсан бүтээгдэхүүний тоо	1/кг	тоо	Гомдолтой байгаагаа илэрхийлсэн, гомдол мэдүүлсэн хүмүүсийн тоог борлуулсан бүтээгдэхүүний тоонд харьцуулсан харьцаа
6	Ёс зүйн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтын үнийн хэсэг	Ёс зүйн бизнесийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө	төг/төг	тоо	Ёс зүйн үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийн мөнгөн дүн
7	Байгаль орчны тогтвортой тайлангийн тоо	Компаний байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаарх зөрэг / сөрөг баримт бичгийн жилийн тоо	1	хувь	Компаний байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаарх зөрэг, сөрөг баримтуудын харьцаа илэрхийлнэ.
8	Нийлүүлэгчийн тооны хэсэг	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зөрчилгүй	1	тоо	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зөрчилгүй ханган нийлүүлэгчдийн фракц буюу нийлүүлэгчийн

		ханган нийлүүлэгчдийн фракц			тоо
9	Харилцаа, холбооны үзүүлэлт	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарттай тохиорхгүй байгаа тул ханган нийлүүлэгчидтэй хийсэн гэрээний тоо	1	тоо	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагвааны зөрчилгүй ханган нийлүүлэгчдийн фракц буюу харилцаа, холбооны үзүүлэлт
3. Эдийн засгийн үзүүлэлтүүд, 3.1 Ажилчдын үзүүлэлтүүд					
1	Ажилчдын зардал	Цалингийн зардал/үйлдвэрлэлийн зардал	төг/UP	хувь	Үйлдвэрлэлийн нийт зардал цалингийн зардалын эзлэх хувь хэмжээг харуулна. Харьцаа өндөр байх тусам үнэлгээ өндөр гэж үзнэ.
2	Ажилчдын хөдөлмөрийн хугацаа	Ажилчдын хөдөлмөрийн дундаж хугацаа	цаг	чанар	Ажилчдын хөдөлмөрийн хугацаа нь календарьн стандарт цагт үндэслэнэ. Цалингийн хэмжээ болон ажлын цаг харьцангуй үзүүлэлт гол нелөөлнө. Жич, цалин хэмжээ дундаж үед ажиллах цаг богино үед ажилчдад зөрөг нелөөтэй үзэн үнэлгээ өндөр байна.
3	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах зардал	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах нийт зардал	төг	чанар	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын зардал өндөр байх тусам ажилчдад зөрөг нелөөлтэй гэж үзэн өндөр үнэлэгдэнэ. Ижил төрлийн үйлдвэр болон стандарттай харьцуулан эксперт үнэлнэ.
4	Дуу чимээний түвшин	Ажиллаж байгаа станцуудад дууны даралтын түвшин	дБ	чанар	Дуу чимээ бага байх тусам үнэлгээ өндөр байна. Ижил төрлийн үйлдвэр болон стандарттай харьцуулан, экспертээр үнэлүүлнэ.
5	Ажилчдын хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт	Ажилчын мэргэжлийн боловсрол, хувь хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт	төг	чанар	Ажилчдын боловсрол, хувь хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр илэрхийлнэ. Экспертийн үнэлгээнд үндэслэнэ.
6	Ажилчдын боловсролын цаг	Нэг ажилтанд ногдох боловсролын дундаж цаг	цаг	чанар	Ажилчдын мэдлэг, боловсролыг дээшүүлэхэд зарцуулсан цагаар илэрхийлнэ. Экспертийн үнэлгээнд үндэслэнэ.
7	Ажилчдын санал болгосон сайжруулалтын тоо	Нэг ажилтанд ногдох үйлдвэрлэлийн чанар, нийгэм, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал зэргийг сайжруулах үйл ажиллагааны тоо	ш	тоо	Ажилчдын санал болгосон сайжруулах үйл ажиллагааны тоо

Тайлбар: UP-үйлдвэрлэсэн нэгж

*Хавсралт 2а. Шалгуур үзүүлэлтийн сонголтын экспертийн үнэлвээний хуудас*

Салбар: \_\_\_\_\_

Дэд салбар: \_\_\_\_\_

№	Шалгуур үзүүлэлт	Сонгосон эсэх, /тийм-1, үгүй-0/	Тайлбар

Эксперт: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Огноо:

*Хавсралт 2б. Шалгуур үзүүлэлтийн сонголтын санал нийцлийн хуудас*

Салбар: \_\_\_\_\_ Дэд салбар: \_\_\_\_\_

№	Шалгуур үзүүлэлт	Эксперт 1	Эксперт 2	.....	Эксперт n	Нийт дүн	Санал нийцлийн хувь

Эксперт 1: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Эксперт 2: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

.....

Эксперт n: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Огноо:

**Хаасралт З. Технологийн түвшний үнэлгээний хуудас**

Салбар: \_\_\_\_\_

Дэд салбар: \_\_\_\_\_

Төслийн нэр: \_\_\_\_\_

Төслийн зорилго: \_\_\_\_\_

№	Шалгуур үзүүлэлт	Томьёо	Утга: Бүрэлдэхүүн 1	Утга: Бүрэлдэхүүн 2	Үзүүлэлтийн тооцоолсон утга	Үзүүлэлтийн оноо	Хөрвүүлсэн оноо	Тайлбар
	Нийгмийн хүчин зүйл							
	Багцын дүн							
	Байгаль орчны хүчин зүйл							
	Багцын дүн							
	Эдийн засгийн хүчин зүйл							
	Багцын дүн							
	Нийт оноо							
	Авбал зохих оноо							
	Авбал зохих оноонд эзлэх хувь							

Албан хаагч 1 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Албан хаагч 2 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Албан хаагч 3 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Огноо:

**Хавсралт 4. Төхнологийн түвшний үнэлгээний нээгдсэн дүүнэлт**

Салбар: \_\_\_\_\_

Дэд салбар: \_\_\_\_\_

№	Төслийн нэр	ТЕЗ-ын үнэлгээ, хувиар	ҮХГ-н үнэлгээ, хувиар	Үнэлгээний дундаж, хувиар	Төслийн эрэмбэ	Төслийн Иж бүрэн үнэлгээний оноо (3 хуртэл)	Тайлбар

Албан хаагч 1 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Албан хаагч 2 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Албан хаагч 3 : \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Огноо:

Баталгаажуулсан:

Эрх бүхий албан тушаалтан: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Огноо: